



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар A/201

Батширээт сум

**Хяналт тавих, хүлээж авах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хууль бус мод бэлтгэл, ойн дагалт баялаг ашиглалт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх камер суурилуулах ажилд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б. Төрмөнх – Засаг даргын орлогч

Гишүүд:

Т.Санчир – Хэсгийн төлөөлөгч

Ч.Түшиг - Засаг даргын Тамгын газрын жолооч

2. Ажлын гүйцэтгэлд гэрээний дагуу хяналт тавьж, хүлээж авахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



232501397